



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цогт сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/017/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Алтай хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Цэрэнханд
Утас: 99086381
Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn
Аудитор: Э.Сүнжидмаа
Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.03.25 № 131

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цогт сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Цогт сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, 16 дугаар зүйлийн 16.5.2, 41 дүгээр зүйлийн 41.2.1 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Газрын төлбөрийн орлого 3,552.4 мянган төгрөг, ан амьтны нөөц ашигласны төлбөр 26,520.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан,
- Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 894,982.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

8225020367

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд зохион байгуулсан сумын 100 жилийн ойн арга хэмжээний зардалд 100,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын захирамжаар олгосон байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогыг 654,204.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 687,038.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 4,120.7 мянган төгрөгөөр буюу 101.0 хувьтай биелүүлсэн байна.

Засгийн газрын 2024 оны 231 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин нэмсэн, мөн оны 83 дугаар тогтоолоор Төрийн захиргааны албан хаагчид 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн урамшууллыг олгожээ.

“Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор нийт 4 орон тоо нэмэгдсэн байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 1,334,767.4 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 105,924.7 мянган төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Санхүүжилтийг Засаг даргын Тамгын газарт 53,275.6 мянган төгрөгийн, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 20,105.0 мянган төгрөг, ерөнхий боловсролын сургуульд 43,133.5 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн сан, сумын ойн хандив болон бусад эх үүсвэрээс 1,228,507.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 17 зорилт 130 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 90.1 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



T. Gunjidmaa

Т.ГҮНЖИДМАА

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөг)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,259,726.6	1,307,050.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	211,406.0	360,976.7
33	АВЛАГА	291,459.8	270,352.9
34	УРЬДЧИЛГАА	0.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	306,360.8	400,293.6
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	10,697.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	450,500.0	264,730.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,934,053.0	1,830,959.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,934,053.0	1,830,959.5
39200	Биет хөрөнгө	1,693,679.0	1,590,585.5
39300	Биет бус хөрөнгө	240,374.0	240,374.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,193,779.6	3,138,009.6
4	НИЙТ ӨР ТӨЛБЭР	59,675.6	120,305.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	59,675.6	120,305.4
41300	Өглөг	59,675.6	120,305.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,134,104.0	3,017,704.3
51	Засгийн газрын хувь оролцоо	3,134,104.0	3,017,704.3
51100	Засгийн газрын оруулсан капитал	333,028.0	333,028.0
51200	Хуримтлагдсан үр дүн	2,720,883.7	2,604,484.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	80,192.3	80,192.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,193,779.6	3,138,009.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган төгрөг)


Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,574,902.6	2,872,773.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	423,533.4	686,271.5
110	Орлогын албан татвар	245,530.1	538,907.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	249,581.6	546,252.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(4,051.6)	(7,345.1)
113	Хөрөнгийн албан татвар	125,911.7	127,643.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	52,091.7	19,720.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,220,311.6	125,932.5
120	Нийтлэг татварын бус орлого	1,220,311.6	125,932.5

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,931,057.6	2,060,569.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,944,142.3	2,350,960.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,944,142.3	2,350,960.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,519,874.2	2,303,388.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	472,655.1	776,786.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,093.4	116,740.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	477,732.8	542,117.2
2104	Хангамж, бараа материалын зардал	42,476.0	29,584.7
2105	Нормативт зардал	0.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,285.2	43,950.8
2107	Томилолт, зочны зардал	16,458.0	18,538.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,865.7	4,102.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	402,308.0	771,568.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,424,268.1	47,572.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,630,760.3	521,812.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	443,134.5	655,212.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,187,625.8	(133,399.7)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөг)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,490,594.3	2,808,912.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	423,533.4	686,271.5
110	Орлогын албан татвар	245,530.1	538,907.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	249,581.6	546,252.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(4,051.6)	(7,345.1)
113	Хөрөнгийн албан татвар	125,911.7	127,643.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	52,091.7	19,720.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,078.2	4,769.5
1181	Газрын төлбөр	13,022.1	14,898.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	35,991.3	52.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	83,003.3	85,071.1
120	Нийтлэг татварын бус орлого	83,003.3	85,071.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,984,057.6	2,037,569.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,751,635.9	2,061,577.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,751,635.9	2,061,577.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,274,367.8	2,014,005.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	472,655.1	772,537.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,093.4	96,848.4



2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,258.7	454,027.9
2104	Хангамж, бараа материалын зардал	43,510.7	44,546.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,969.5	45,425.8
2107	Томилолт, зочны зардал	16,458.0	18,538.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	447,532.3	4,252.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	176,890.1	577,828.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,477,268.1	47,572.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	738,958.4	747,334.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	701,889.5	522,764.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	701,889.5	522,764.0
2200	Дотоод эх үүсвэрээр	701,889.5	522,764.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(701,889.5)	(522,764.0)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	(75,000.0)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	75,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	37,068.9	149,570.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	174,337.1	211,406.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	211,406.0	360,976.7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөг)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,946,478.2	0.0	1,946,478.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,946,478.2	0.0	1,946,478.2
9	Тайлант үеийн үр дүн	1,187,625.8	0.0	1,187,625.8
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,134,104.0	0.0	3,134,104.0
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,134,104.0	0.0	3,134,104.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	17,000.0	0.0	17,000.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,151,104.0	0.0	3,151,104.0
19	Тайлант үеийн үр дүн	(133,399.7)	0.0	(133,399.7)
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,017,704.3	0.0	3,017,704.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөг)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,721,345.70	2,345,971.70	375,374.00	86.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,931,471.40	1,783,529.08	147,942.32	92.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,872,367.40	1,735,956.49	136,410.91	92.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	784,000.00	772,537.85	11,462.15	98.5
210101	Үндсэн цалин	245,000.00	488,514.71	(243,514.71)	199.4
210102	Нэмэгдэл	539,000.00	247,977.88	291,022.12	46.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00	0.00	
210104	Урамшуулал	0.00	14,664.10	(14,664.10)	
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	21,381.16	(21,381.16)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,941.00	96,848.42	1,092.58	98.9
210201	Тэтгэврийн даатгал	69,381.00	68,668.51	712.49	99.0
210202	Тэтгэмжийн даатгал	7,140.00	7,052.71	87.30	98.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,570.00	3,760.81	(190.81)	105.3
210204	Ажилгүйдлийн даатгал	3,570.00	3,313.79	256.21	92.8
210205	Эрүүл мэндийн даатгал	14,280.00	14,052.62	227.38	98.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	524,764.20	454,027.94	70,736.26	86.5
210301	Гэрэл, цахилгаан	30,800.00	29,916.96	883.04	97.1
210302	Түлш, халаалт	485,564.20	417,310.98	68,253.22	85.9
210303	Цэвэр, бохир ус	8,400.00	6,800.00	1,600.00	81.0
2104	Хангамж, бараа материалын зардал	40,732.00	37,766.80	2,965.20	92.7
210401	Бичиг хэрэг	12,234.00	10,129.00	2,105.00	82.8
210402	Тээвэр, шатахуун	23,300.00	22,785.55	514.45	97.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,204.00	3,215.75	(11.75)	100.4
210404	Ном, хэвлэл	500.00	0.00	500.00	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100.00	0.00	100.00	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,394.00	1,636.50	(242.50)	117.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	77,792.00	77,407.20	384.80	99.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,403.00	14,392.40	10.60	99.9
210602	Тавилга	16,589.00	16,589.00	0.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00	0.00	
210604	Урсгал засвар	46,800.00	46,425.80	374.20	99.2
2107	Томилолт, зочны зардал	21,516.20	18,538.00	2,978.20	86.2
210702	Дотоод албан томилолт	21,516.20	18,538.00	2,978.20	86.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,040.00	4,252.08	787.92	84.4


210804	Тээврийн хэрэгслийн татвар	500.00	498.53	1.48	99.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	450.00	410.79	39.21	91.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,150.00	993.00	157.00	86.3
210807	Газрын төлбөр	2,940.00	2,349.76	590.24	79.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	320,582.00	274,578.20	46,003.80	85.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	317,082.00	271,329.00	45,753.00	85.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,500.00	3,249.20	250.80	92.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,104.00	47,572.59	11,531.41	80.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,104.00	47,572.59	11,531.41	80.5
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	48,804.00	39,258.59	9,545.41	80.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,500.00	7,500.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,800.00	814.00	1,986.00	29.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	711,874.30	487,442.62	224,431.69	68.5
223001	Бусад хөрөнгө	711,874.30	487,442.62	224,431.69	68.5
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	78,000.00	75,000.00	3,000.00	96.2
230001	Эргэж төлөгдөх зээл	78,000.00	75,000.00	3,000.00	96.2
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,721,345.70	2,516,740.05	204,605.65	92.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,588,345.70	2,433,835.74	154,509.96	94.0
320001	Орон нутгийн төсвөөс	2,039,471.40	1,909,111.91	130,359.49	93.6
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	548,874.30	524,723.83	24,150.47	95.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	133,000.00	82,904.30	50,095.70	62.3
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52,000.00	82,904.30	(30,904.30)	159.4
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	81,000.00	0.00	81,000.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	82,403.89	(82,403.89)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	253,172.24	(253,172.24)	

2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөг)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	337,003.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	337,003.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	313,370.09

2104	Хангамж, бараа материалын зардал	6,779.46
210401	Бичиг хэрэг	-
210402	Тээвэр, шатахуун	6,779.46
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	306,590.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	306,590.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,633.23
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,633.23
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	23,633.23
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	337,003.32
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	337,003.32
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	24,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	311,908.32
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	595.00



Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар нийт 82.9 сая төгрөгийн 1 алдаа илрүүлснийг аудитын явцад залруулсан байна.

Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланг 82.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 135.9 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 135.9 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 албан шаардлага хүргүүлсэн.

3.1.1 Харьяа байгууллагууд

Цогт сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн ба сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

3.1.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар санхүүгийн тайлангийн бүртгэл, тайлагналыг 270.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 9 алдааг залруулж, 524.9 сая төгрөгийн 7 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

3.1.3 Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 369.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 9 алдааг залруулж, 24.8 сая төгрөгийн төлбөрийн акт, 270.1 сая төгрөгийн 7 зөрчил илрүүлж, давтан гаргахгүй байх албан шаардлага, 75.0 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн байна.


3.2 Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар өглөг, орлоготой холбоотой 82.9 сая төгрөгийн 1 алдааг залруулсан.

Аудитаар нийт 135.7 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлснээс 30.0 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага, 105.9 сая төгрөгийн 1 заалт зөвлөмжийг хүргүүлж байна.

3.3 Албан шаардлага

1. Орон нутгийн орлогыг төлөвлөснөөс азрын төлбөрийн орлогыг 3,552.4 мянган төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр 26,520.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын



хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 41 дүгээр зүйлийн 41.1-т "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 06 дугаар тогтоолыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллан, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,535.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 640.5 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 894.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Батлагдсан төсөө, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал


Илрүүлэлт:

Орон нутгийн төсвөөс 105.9 сая төгрөгийг дутуу санхүүжүүлсэн. Сумын орон нутгийн төсвөөс Засаг даргын Тамгын газарт 14.3 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 4.0 сая төгрөг, Ерөнхий боловсролын сургуульд 3.7 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус илүү олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16-т "төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох; 41 дүгээр зүйлийн 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" Цогт Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 33 дугаар тогтоолтой нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хуваарийн дагуу нэгж байгууллагуудад санхүүжилтийг олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл
/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Бүгд	Өөрчлөлтгүй	Хязгарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах	Түвэрт	Нийт зөрчил		Үүнээс									
							Тоо	Дун	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	Албан тушаалтны тоо
Цогт сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан	1	-	1	-	-	-	2	30,072.4	2	30,072.4	-	-	-	-	-	-	-	
Цогт сумын Засаг даргын Тамгын газар	1	-	1	-	-	-	9	369,995.0	7	270,199.5	1	75,000.0	-	-	-	-	-	
Цогт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	-	-	-	1	-	1	690.0	1	690.0	-	-	-	-	-	-	-	
Цогт сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	-	-	-	1	-	4	453,329.6	4	453,329.6	-	-	-	-	-	-	-	
Цогт сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Цогт сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	-	-	-	1	-	2	70,968.3	2	70,968.3	-	-	-	-	-	-	-	
Дүн	6	-	2	-	4	-	18	925,055.3	16	825,259.8	1	75,000.0	1	75,000.0	-	-	-	



Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Цогт сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан	1	82,904.3	-	-	1	82,904.3	1	82,904.3	-	-	-	-
Цогт сумын Засаг даргын Тамгын газар	9	369,994.0	-	-	9	369,994.0	9	369,994.0	-	-	-	-
Цогт сумын ИТХ	1	945.0			1	945.0	1	945.0				
Цогт сумын Орон нутгийн хөгжлийн сан	5	266,407.5	-	-	5	266,407.5	5	266,407.5	-	-	-	-
Цогт сумын Хоршоо хөгжүүлэх сан	3	3,183.8	-	-	3	3,183.8	3	3,183.8	-	-	-	-
Дүн	19	723,434.6	-	-	19	723,434.6	19	723,434.6	-	-	-	-

